



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/207

Ховд

Кемпийн газар түр эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Нутгийн зам” хөтөлбөрийн хүрээнд Чандмань сумын төвийг хатуу хучилттай авто замаар холбох авто замын барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчээр шалгарч, гэрээ байгуулсан “Хотгор зам” ХХК-д замын барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх хугацаанд ашиглах кемпийн газрыг заасан цэгт нь түр хугацаагаар ашиглуулсугай.

2. Уг төсөл арга хэмжээг хэрэгжихтэй холбогдон кемп байгуулах газрын түр зөвшөөрөл, бусад холбогдох шаардлагатай зөвшөөрлийг түргэн шуурхай гаргаж ажиллахыг Зэрэг сумын Засаг дарга (Б.Батбилэг), Манхан сумын Засаг дарга (Т.Лхагвасүрэн), Чандмань сумын Засаг дарга (З.Онолбаатар) нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, кемп байгуулах газрын түр зөвшөөрөл гаргах ажлыг зохион байгуулан гаргаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Н.Ганзориг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1046